



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/380

Хэрлэн сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.3 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг эрүүл мэндийн салбарт зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга:

Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын
Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга

Гишүүд:

Мэргэжлийн хяналтын газрын хөдөлмөрийн
хяналтын улсын байцаагч

Нийгмийн бодлогын хэлтсийн Хүн ам,
нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт,
гэр бүл, хүүхэд залуучуудын бодлого
хариуцсан мэргэжилтэн

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын
Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн
аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн

Ажил олгогч эздийн холбооны тэргүүн

“Оч Манлай” ХХК-ийн захирал

2.Эрүүл мэндийн салбарт хийгдэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг өндөр түвшинд зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн даргад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010860